



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/84/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.4 Зөвлөмж	14
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 86

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020105

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>96,576,891.52</u>	<u>111,547,801.31</u>
33	АВЛАГА	23,440,571.72	22,985,771.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	760,292.00	305,492.00
335	Бусад авлага	22,680,279.72	22,680,279.72
3352	Хувь хүмүүсээс авах авлага	22,680,279.72	22,680,279.72
35	БАРАА МАТЕРИАЛ	73,136,319.80	88,562,029.59
351	Түүхий эд материал	34,435,727.00	54,835,994.00
35110	Тусгай зориулалттай материал	33,941,727.00	54,341,994.00
35130	Эм боох материал	494,000.00	494,000.00
354	Хангамжийн материал	38,700,592.80	33,726,035.59
35410	Бичиг хэргийн материал	2,496,300.00	670,500.00
35420	Аж ахуйн материал	10,044,953.00	9,532,783.00
35430	Сэлбэг хэрэгсэл	380,000.00	380,000.00
35450	Барилгын засварын материал	10,578,610.00	9,419,060.00
35460	Хүнсний материал	209,549.00	162,510.00
35470	Бусад хангамжийн материал	14,991,180.80	13,561,182.59
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,615,365,170.81</u>	<u>2,460,498,457.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,615,365,170.81	2,460,498,457.13
392	Биет хөрөнгө	2,311,327,670.81	2,156,498,457.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,676,812,999.94	1,676,812,999.94
39202	Хуримтлагдсан элэгдэл	(120,201,155.06)	(175,358,963.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	393,773,072.03	421,549,424.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,102,927.31)	(193,528,559.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	200,864,414.64	204,252,141.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(60,691,860.34)	(86,502,612.61)
39209	Зам, гүүрийн байгууламж	44,792,800.00	44,792,800.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,198,200.08)	(16,797,300.12)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	294,200.00	50,294,200.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	200,000,000.00	200,000,000.00
39217	Ном	30,984,327.00	30,984,327.00
393	Биет бус хөрөнгө	304,037,500.00	304,000,000.00
39301	Програм хангамж	1,700,000.00	1,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,662,500.00)	(1,700,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	304,000,000.00	304,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,711,942,062.33</u>	<u>2,572,046,258.44</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,711,942,062.33</u>	<u>2,572,046,258.44</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,711,942,062.33	2,572,046,258.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,288,663,897.85	1,288,663,897.85
51101	Өмч: - төрийн	1,288,663,897.85	1,288,663,897.85
512	Хуримтлагдсан үр дүн	(31,776,001.93)	(171,671,805.82)
51210	Өмнөх үеийн үр дүн	(31,776,001.93)	(31,776,001.93)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(139,895,803.89)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,455,054,166.41	1,455,054,166.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,711,942,062.33</u>	<u>2,572,046,258.44</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,115,274,747.81	1,630,324,096.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	599,394,181.81	77,106,498.03
120	Нийтлэг татварын бус орлого	599,394,181.81	77,106,498.03
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	599,394,181.81	77,106,498.03
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	599,394,181.81	77,071,498.03
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө		57,484,079.24
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		19,587,418.79
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,515,880,566.00	1,553,217,598.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,226,089,700.00	1,306,585,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,226,089,700.00	1,306,585,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,890,866.00	17,078,498.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,585,266.00	533,298.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,305,600.00	5,945,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	250,900,000.00	229,553,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	250,900,000.00	229,553,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,600,578,488.57	1,770,219,899.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,600,578,488.57	1,770,219,899.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,478,525,972.45	1,692,966,371.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,028,457,549.24	1,064,260,862.66
210101	Үндсэн цалин	937,284,748.24	980,581,539.66
210104	Урамшуулал	91,172,801.00	83,679,323.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,117,052.64	137,301,848.53
210201	Тэтгэврийн даатгал	96,941,984.11	94,273,998.81
210202	Тэтгэмжийн даатгал	-	10,520,999.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,351,291.22	9,086,299.79
210204	Ажилгүйдлийн даатгал	2,088,172.16	2,177,998.55
210205	Эрүүл мэндийн даатгал	20,735,605.16	21,242,552.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,995,966.00	213,682,865.81
210301	Гэрэл, цахилгаан	6,615,722.00	5,513,809.81
210302	Түлш, халаалт	182,384,808.00	202,553,600.00
210303	Цэвэр, бохир ус	13,995,436.00	5,615,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,922,010.00	14,284,251.79
210401	Бичиг хэрэг	1,336,750.00	3,793,098.00
210402	Тээвэр, шатахуун	599,800.00	1,532,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,294,060.00	3,062,333.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	959,400.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,688,800.00	5,776,520.00
2105	Нормативт зардал	998,050.00	3,731,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	516,650.00	1,860,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	481,400.00	1,871,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,827,000.00	9,146,550.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	-	64,000.00
210604	Урсгал засвар	3,827,000.00	9,082,550.00
2107	Томилолт, зочны зардал	160,000.00	591,000.00
210702	Дотоод албан томилолт	160,000.00	591,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,101,600.00	7,187,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,305,600.00	7,187,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,946,744.57	242,780,192.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,991,700.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,901,200.00	6,749,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	96,053,844.57	236,030,792.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	122,052,516.12	77,253,528.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,898,847.70	65,665,231.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,723,084.70	58,270,231.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,585,266.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,590,497.00	7,395,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,907,034.00	7,870,834.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,907,034.00	7,870,834.19
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,246,634.42	3,717,463.02
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,246,634.42	3,717,463.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	514,696,259.24	(139,895,803.89)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,324,754.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,921,904.00	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,402,850.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,324,754.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	511,371,505.24	(139,895,803.89)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,288,663,897.85	1,455,054,166.41	-31,776,001.93	0.00	2,711,942,062.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,288,663,897.85	1,455,054,166.41	-31,776,001.93	0.00	2,711,942,062.33
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,288,663,897.85	1,455,054,166.41	-31,776,001.93	0.00	2,711,942,062.33
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,288,663,897.85	1,455,054,166.41	-31,776,001.93	0.00	2,711,942,062.33
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,288,663,897.85	1,455,054,166.41	-31,776,001.93	0.00	2,711,942,062.33
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-139,895,803.89	0.00	-139,895,803.89
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,288,663,897.85	1,455,054,166.41	-171,671,805.82	0.00	2,572,046,258.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,522,381,202.00</u>	<u>1,553,252,598.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,522,381,202.00	1,553,217,598.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,226,089,700.00	1,306,585,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,226,089,700.00	1,306,585,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,391,502.00	17,078,498.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,500,636.00	10,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,585,266.00	533,298.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,305,600.00	5,945,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	250,900,000.00	229,553,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	250,900,000.00	229,553,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,512,836,202.00</u>	<u>1,529,572,598.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,512,836,202.00	1,529,572,598.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,390,838,300.88	1,452,366,108.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,028,912,349.24	1,063,806,062.66
210101	Үндсэн цалин	937,739,548.24	980,126,739.66
210104	Урамшуулал	91,172,801.00	83,679,323.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,117,052.64	137,301,848.53
210201	Тэтгэврийн даатгал	96,941,984.11	94,273,998.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,351,291.22	9,086,299.79
210204	Ажилгүйдлийн даатгал	2,088,172.15	2,177,998.55
210205	Эрүүл мэндийн даатгал	20,735,605.16	21,242,552.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,995,966.00	213,682,865.81
210301	Гэрэл, цахилгаан	6,615,722.00	5,513,809.81
210302	Түлш, халаалт	182,384,808.00	202,553,600.00
210303	Цэвэр, бохир ус	13,995,436.00	5,615,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,872,183.00	13,100,531.79
210401	Бичиг хэрэг	1,499,550.00	1,729,298.00
210402	Тээвэр, шатахуун	599,800.00	1,532,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,526,883.00	3,062,333.79
210404	Ном, хэвлэл	599,200.00	2,514,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	959,400.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,687,350.00	4,142,500.00
2105	Нормативт зардал	1,090,550.00	2,353,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	497,150.00	1,860,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	593,400.00	493,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,997,000.00	8,140,900.00
210604	Урсгал засвар	4,997,000.00	7,999,900.00
2107	Томилолт, зочны зардал	160,000.00	591,000.00
210702	Дотоод албан томилолт	160,000.00	591,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,101,600.00	7,427,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,305,600.00	7,427,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,591,600.00	5,962,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,991,700.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,599,900.00	5,962,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,997,901.12	77,206,489.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,843,596.70	65,618,192.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,667,833.70	58,223,192.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,585,266.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,590,497.00	7,395,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,907,670.00	7,870,834.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,907,034.00	7,870,834.19
	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	636.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,246,634.42	3,717,463.02
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,246,634.42	3,717,463.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,545,000.00</u>	<u>23,680,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,545,000.00	23,680,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,545,000.00	23,680,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,545,000.00	23,680,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,545,000.00	23,680,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(9,545,000.00)</u>	<u>(23,680,000.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,536,139,100.00	1,524,585,802.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,536,139,100.00	1,524,585,802.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,470,514,200.00	1,458,967,610.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,064,938,500.00	1,063,806,062.66
210101	Үндсэн цалин	981,235,700.00	980,126,739.66
210104	Урамшуулал	83,702,800.00	83,679,323.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,844,300.00	137,301,848.53
210201	Тэтгэврийн даатгал	94,274,000.00	94,273,998.81
210202	Тэтгэмжийн даатгал	10,521,000.00	10,520,999.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,086,300.00	9,086,299.79
210204	Ажилгүйдлийн даатгал	2,178,000.00	2,177,998.55
210205	Эрүүл мэндийн даатгал	21,785,000.00	21,242,552.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,553,600.00	213,682,865.81
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	5,513,809.81
210302	Түлш, халаалт	202,553,600.00	202,553,600.00
210303	Цэвэр, бохир ус	13,000,000.00	5,615,456.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,488,000.00	9,467,233.79
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,196,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,488,000.00	1,182,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,000.00	3,062,333.79
210404	Ном, хэвлэл	500,000.00	414,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,492,500.00
2105	Нормативт зардал	2,375,000.00	2,353,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,875,000.00	1,860,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	493,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,900,000.00	27,870,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,900,000.00	19,871,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,999,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	591,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	591,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй	1,000,000.00	982,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,000,000.00	982,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,914,800.00	2,912,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,914,800.00	2,912,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,624,900.00	65,618,192.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,624,900.00	65,618,192.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,224,900.00	58,223,192.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,400,000.00	7,395,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,536,139,100.00	1,524,585,802.78
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,306,585,500.00	1,302,868,036.98
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,306,585,500.00	1,302,868,036.98
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	229,553,600.00	221,682,765.80
132001	Орон нутгийн төсвөөс	229,553,600.00	221,682,765.80
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45390866.00	17078498.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45390866.00	17078498.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10805600.00	17078498.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	3633298.00
210401	Бичиг хэрэг	-	533,298.00
210402	Тээвэр, шатахуун	-	350,000.00
210404	Ном, хэвлэл	-	2,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5500000.00	3950000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,500,000.00	3,950,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4305600.00	6445200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,305,600.00	6,445,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1000000.00	3050000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	3,050,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49490002.00	17078498.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49490002.00	17078498.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,391,502.00	11,133,298.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,098,500.00	5,945,200.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын захирал, аудитор Р.Цанжидмаа гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсролын тухай хуульд заасны дагуу Есөнбулаг сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Суралцагч бүрийн сурлагын чанарыг ахиулна”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 2,115.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 42.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 33.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 1,630.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 32.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 26.0 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5.2 хувиар буюу 139.9 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 22.9 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр буурсан байна.

Шүүхийн шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд олгосон цалин 22.6 сая төгрөгийн авлага одоо болтол барагдаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 88.5 сая төгрөг болж 15.4 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 79.0 сая төгрөгийн, хандиваар үнэ төлбөргүйгээр 19.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 83.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 88.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,934.4 сая төгрөг болж 81.2 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 23.7 сая төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 57.5 сая төгрөгийн хөрөнгө орлого авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,572.0 сая төгрөг болж 139.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 23.0 хувиар буюу 485.0 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 171.7 сая төгрөгийн алдагдалтай болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,636.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 100.6 сая төгрөгөөр өсгөж, 1,536.1 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь хүүхдийн хоолны зардал (1500 төгрөг) болж өссөнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 5 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,536.1 сая төгрөгийн төсөв баталснаас 1,306.6 сая төгрөгийг улсын төсвөөс 229.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 229.5 сая төгрөг, улсын төсвөөс 1,306.6 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт 1,536.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,524.6 сая төгрөгийг зарцуулж 3.7 сая төгрөгийг улсын төсөвт, 7.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,524.6 сая төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 1.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 1.0 сая төгрөг, томилот, зочны зардал 0.9 сая төгрөг, бусад зардлууд 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчаас 11.9 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 5.9 сая төгрөг нийт 17.8 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 3.6 сая төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 4.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 6.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3.1 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим системд 1,762.1 сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулахаас 1,762.1 сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 4.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн. Аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан тухай албан бичиг ирүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар:

- Худалдан авсан хөрөнгийн чанар, ашиглалтын байдлыг үзэх
- Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа хөрөнгийн үнэ, шинж чанарт дүн шинжилгээ хийх
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зөрчил, авлага барагдуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Үр дүнгийн урамшууллыг 0.5 сая төгрөг дутуу, 1.0 сая төгрөг илүү олгосон нь ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно", 4.7-т "Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Хүнсний материалын няравын тайлан хүнсний материалын менюны зарлагаас 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шүүхийн шийдвэрээр олгогдсон цалингийн 22.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт /Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дахь заалт /Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна/ заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	4	1.6	-	-	2	1.6	2	0.0		
	Дүн	4	1.5	-	-	2	1.6	2	0.0		

/сая төгрөгөөр/